



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/137

Мандалговь

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1, 38.2, 38.4 дэх заалтууд, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах иргэний хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Г.Чагдаржавын гудамж-4-403г тоот)-т байршилтай иргэн Ганбат овогтой Дэмбэрэл (ЗА:76031613)-ийн орон сууцны зориулалттай 300 м.кв (0,03га) газрыг иргэн Шинэхүү овогтой Мянганжаргал (ЗЮ:89050410)-д зориулалтаар нь шилжүүлж 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (С.Бат-Оргил), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/272 дугаар захирамжийн иргэн Г.Дэмбэрэл-д холбогдох хэсэг мөн газар эзэмших 000120203 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

48121006